



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 1/06

Улаанбаатар хот

Л.Алтангэрэлийг туршлага солилцох уулзалт,
сургалтад хамруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сингапур улсад зохион байгуулагдах Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн банкны 2030 Усны Нөөцийн Бүлгийн хамтын ажиллагааны хүрээнд болох туршлага солилцох уулзалт, сургалтад тус албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Лхагвын Алтангэрэлийг 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийг дуустал хугацаанд хамруулсугай.

2. Л.Алтангэрэлд дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.33 дахь заалтын дагуу сургалтад хамрагдах хугацааны цалинг олгохыг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

3. Туршлага солилцох уулзалт, сургалтын тайланг ирснээс хойш ажлын 5 хоногийн дотор Захиргаа, санхүүгийн хэлтэст ирүүлэхийг Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн Л.Алтангэрэлд даалгасугай.

4. Л.Алтангэрэлийн эзгүй байх хугацаанд дотоод ажил үүргийн хуваарийн дагуу ажлын байрны тодорхойлолтод заасан болон цаг үеийн шаардлагатай үүрэг даалгаврыг алдагдуулахгүй зохион байгуулж ажиллахыг Инженерийн байгууламжийн хэлтэс /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

